



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ
ХОРООНЫ ДАРГА С.АДЪЯАСҮРЭН ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.02.23 № 3/315
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

Харилцаа холбооны зохицуулах хорооны удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Нягтлан бодогчдын олон улсын холбооноос баталсан Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын гарын авлагын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, гарын авлагын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь дүн хэмжээ болон илчлэл тодруулгыг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгадаг. Түүнчлэн аудитаар удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн зарчим, хийсэн чухал тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлдэг.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



“ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ

ХОРОО”-НЫ 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараахь хаягаар харилцана уу:**

Аудитын тайлан

САГ-ын дарга, тэргүүлэх
аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Аудитын менежер: Я.Самбууням
Утас: 260512

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Аудитор: Н.Нямдаваа
Утас: 260512

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Үндэсний аудитын газар
Засгийн газрын IY байр
Бага тойруу 6
Улаанбаатар-46
Монгол Улс
Цахимхуудас: www.audit.mn

Ворлдвайд файнэнс аудит ХХК
Захирал: Ч.Байгаль
Утас: 99091342
Ахлах аудитор: З.Сумьяа
Утас: 99087154

2017 оны 2 дугаар сар

АГУУЛГА

1. Аудитын хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль ,эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Материаллаг байдлын түвшин
7. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
8. Шилэн дансны мэдээлэл
9. Олж тогтоосон гол эрсдлүүд, түүний үр дагавар
10. Гол онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар
12. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
17. Зөвлөмж
18. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль, эрх зүйн үндэслэл

“Төрийн аудит”-ийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1-д, “Төсвийн тухай” хуулийн 8.9.1 дэх заалтыг үндэслэн Төрийн аудитийн тухай хуулийн 18.5 дугаар зүйлд заасан Үндэсний аудитийн бүрэн эрхийн хүрээнд “Харилцаа холбооны зохицуулах хороо”-ны 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд “Ворлдвайд фاینэнс аудит” ХХК аудит хийлээ.

САГ-2017/62/СТА-ТШЗ

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

“Харилцаа холбооны зохицуулах хороо”-ны 2016 оны санхүүгийн тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

"Харилцаа холбооны зохицуулах хороо" нь санхүүгийн тайлангаа УСНББОУС болон түүнд нийцүүлэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, программ хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС -тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

"Харилцаа холбооны зохицуулах хороо"-ны 2016 оны төсвийн санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 1 дүгээр сарын 25-наас 2017 оны 2 дугаар сарын 20-ны хооронд хийхээр төлөвлөн “Ворлдвайд фاینэнс аудит” ХХК-н ахлах аудитор З.Сумъяа хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

“Харилцаа холбооны зохицуулах хороо”-ны 2016 оны санхүүгийн тайланг 2017 оны 1 дүгээр сарын 25-нд ирүүлсэн байна.

“Харилцаа холбооны зохицуулах хороо”-ны 2016 оны дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд 2017 оны 1 дүгээр сарын 25-наас 2017 оны 02 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 2 дугаар сарын 24-нд “Харилцаа холбооны зохицуулах хороо”-ны удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин

“Харилцаа холбооны зохицуулах хороо”-нь Монгол улсын Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай болон бусад холбогдох хуулиуд, УСНББОУС, Сангийн сайдын 2006 оны 388, 2008 оны 352 тоот тушаалаар батлагдсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан тодруулгын маягт, санхүүгийн тайлан

бэлтгэж гаргах аргачлал”-ыг ашиглаж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хуульд өөрчлөлт ороогүй байна.

"Харилцаа холбооны зохицуулах хороо" нь чиг үүргээ хэрэгжүүлэхдээ Харилцаа холбооны тухай, Радио долгионы тухай, Шуудангийн тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай, Олон нийтийн радио телевизийн тухай, Цахим гарын үсгийн тухай, Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай, Зар сурталчилгааны тухай хуулиуд болон холбогдох бусад хууль тогтоомжууд, Улсын их хурал, Засгийн газар, Харилцаа холбооны зохицуулах хорооны хурлын тогтоол шийдвэр, Харилцаа холбооны зохицуулах хорооны даргын тушаалаар баталсан дүрэм, журам, заавар, аргачлалыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа

"Харилцаа холбооны зохицуулах хороо" нь өмчийн бүх төрлийн аж ахуйн нэгж, иргэн харилцаа холбооны зах зээлд үр ашигтай, шударга өрсөлдөх нөхцлийг бүрдүүлэх, тусгай зөвшөөрөл олгох, мэргэжлийн дүгнэлт, шийдвэр гаргах чиг үүрэгтэй. Үндсэн зорилго нь хууль тогтоомжийг хэрэгжүүлэх харилцаа холбооны талаар төрөөс баримталж байгаа бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах тусгай зөвшөөрөл олгох, түүнийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох, радио давтамжийн зурвасыг хувиарлах, дугаарлалтын нэгдсэн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх, үйлчлэгч, хэрэглэгчийн эрх ашгийг тэнцвэртэй хамгаалах бүх нийтийн үйлчилгээний үүргийн хэрэгжилтийг хангуулах, үйлчлэгчийн шударга өрсөлдөх нөхцлийг бүрдүүлэхэд оршино.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д заасны дагуу "Харилцаа холбооны зохицуулах хороо"-ны дарга нь төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

"Харилцаа холбооны зохицуулах хороо"-той холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудын хэрэгжилт хангалтгүй байна.

"Харилцаа холбооны зохицуулах хороо"-ны үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтанд тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар “Харилцаа холбооны зохицуулах хороо”-ны 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 25 -г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад “Харилцаа холбооны зохицуулах хороо”-ны санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан, баталж мөрдөн ажиллаж байна.

“Харилцаа холбооны зохицуулах хороо”-ны санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа комьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитийг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

“Харилцаа холбооны зохицуулах хороо”-ны санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг “Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ны Төсвийн санхүү нягтлан бодох бүртгэлийн “Acolous 3.0” санхүүгийн программаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. "Харилцаа холбооны зохицуулах хороо"-ны дотоод хяналт, эрсдлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцон дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Материаллаг байдлын түвшин

Материаллаг байдлын түвшингийн суурийг тооцохдоо төлөвлөлтийн үе шатанд санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2 хувиар тогтоосонгоор гүйцэтгэлийн шатанд суурь үзүүлэлт болон хувийг өөрчлөхгүйгээр тооцож 106,9 сая төгрөгөөр тогтоосон болно. /ТАБ-СТА-В-1/

Материаллаг байдлын суурийг тооцохдоо өөрийн үйл ажиллагааны орлогоос санхүүждэг байгууллага учраас тус байгууллагын үр дүнгийн тайлангийн нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзэв.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар

"Харилцаа холбооны зохицуулах хороо"-ны жилийн төсвийг Засгийн газар баталж, ажлын тайлан, төсвийн гүйцэтгэлийг Засгийн газарт тайлагнан ажиллаж байна.

"Харилцаа холбооны зохицуулах хороо"-нь 2016 онд үндсэн үйл ажиллагааны орлого 5,000.0 сая төгрөг төлөвлөж, гүйцэтгэлээр 9,105.5 сая төгрөгний орлого бүрдүүлж, 4,105.5 сая төгрөгөөр орлогыг давуулан биелүүлсэн байна. Урсгал зардалд 5,327.7 сая төгрөг байхаар төлөвлөж гүйцэтгэлээр 3,950.7 сая төгрөг зарцуулж 1,377.0 сая төгрөгийн хэмнэлтэй ажилласан байна.

2016 онд хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд 2,292.0 сая төгрөг төлөвлөж гүйцэтгэлээр 1,066.9 сая төгрөг зарцуулсан байна.

Шилэн дансны мэдээлэл

“Харилцаа холбооны зохицуулах хороо” нь Шилэн дансны тухай хуульд заасны дагуу өөрийн байгууллагын мэдээллийг <http://shilendans2015.gov.mn/> цахим хуудсанд шилэн дансны мэдээллийг оруулсан байна.

Олж тогтоосон эрсдэлүүд, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 17 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 25 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

"Харилцаа холбооны зохицуулах хороо" нь зохицуулах үйлчилгээний орлого болон төлбөртэй үйлчилгээний авлагатай холбоотой ажил гүйлгээг харилцагч байгууллагаар гүйлгээ гарсан тухай бүр ерөнхий журнал болон авлага, өглөгийн дэлгэрэнгүй бүртгэлд тусгахгүй сар, улирлаар нэгтгэн нийлбэр дүнгээр ерөнхий журналын бичилт хийж байна.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

"Харилцаа холбооны зохицуулах хороо"-ны 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаа илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, зохицуулах үйлчилгээний орлого, урсгал зардал зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт орлогын 40 хувь, мөнгөн хөрөнгийн 55 хувь, нийт зардлын 60 хувь, нийт хөрөнгийн 30 хувийг тус тус эзэлж байна.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг бус хэмжээний дараах алдаа илэрсэн байна. Үүнд:

1. 2010 онд батлагдсан НББ-ийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж байгаа бөгөөд уг баримт бичигт ямар нэгэн өөрчлөлт ороогүй байгаа нь “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: НББ-ийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулж баталж мөрдөх талаар менежментийн захидлаар зөвлөмж өгөв

2. Санхүүгийн тайланд 3,097.8 сая өгрөгийн авлагыг 2 ,064.3 сая өгрөгийн урьдчилж орсон орлогоор хорогдуулан авлагын дундаж 1 ,033.5 сая өгрөгөөр тайлагнасан байгаа нь Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалын 1 дүгээр хавсралтын 2.14 дэх заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын хугацаанд санхүүгийн тайланд залруулга хийсэн.

3. Санхүүгийн тайланд үйлчилгээний авлага 643 харилцагчийн 3,097.8 сая төгрөг тайлагнагдаж байгааг бод харилцагч бүрт цахим хэлбэрээр тулган баталгаажуулах захидал явуулсан боловч 291 харилцагчаас хариу хүлээн авсны 129 нь буюу 44.3 хувь нь үлдэгдлийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэсэн хариу ирүүлсэн, мөн хүмүүсээс авах авлагын дүнд 2008 онд үүссэн нэр бүхий 6 хүнтэй холбоотой 170.6 сая өгрөгийн үлдэгдэл удаан хугацаанд байгаа нь “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба өлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Менежментийн захидлаар аудитын зөвлөмж өгөв

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитын явцад залруулагдаагүй алдаа үгүй болно.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

"Харилцаа холбооны зохицуулах хороо" нь улсын үргэлд " Төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газар" гэж бүртгэгдсэн байгаа нь статусын хувьд зөрчилтэй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

"Харилцаа холбооны зохицуулах хороо"-ны 2017 оны санхүүгийн тайлангийн явцад үйлчилгээний авлагыг гүйцээж нарийвчлан шалгах.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

"Харилцаа холбооны зохицуулах хороо"-ны 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар 2,064.3 сая өгрөгийн зөрчил, алдааг залруулсан, менежментийн захидлаар 2 зөвлөмж өгсөн.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

"Харилцаа холбооны зохицуулах хороо"-ны 2015 оны санхүүгийн тайланд “Ворлдвайд фاینэнс аудит” ХХК-аас хийсэн аудитаар 2 зөвлөмж өгсөн бөгөөд зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

"Харилцаа холбооны зохицуулах хороо"-ны 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл ажил гүйлгээнүүд холбогдох хууль, тогтоомж УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Харилцаа Холбооны Зохицуулах хорооны 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан

АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

(2016 оны 12 дугаар сарын 31-нээрх)

(төгрөгөөр)

Дансныкод	БАЛАНСЫН ЗҮЙЛ	Тодруулга	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ		2,627,305,578.08	6,715,246,945.23
3101	Кассанд байгаа бэлэн мөнгө		0.00	0.00
310201	Банкинд байгаа бэлэн монго /төгрөгөөр/		2,111,521,631.13	6,701,269,404.36
310202	Банкинд байгаа бэлэн монго /валютаар/		515,783,946.95	13,977,540.87
	АВЛАГА		4,339,585,837.88	3,291,471,120.29
	Дансныавлага		4,388,657,142.88	3,340,542,425.29
3301+3304+3303	Бусад байгууллагаас авах авлага		79,548,545.28	59,708,887.72
330502	Хувь хүмүүсээс авах авлага		183,676,946.23	182,981,946.23
330200	Үйлчилгээний авлага		4,125,431,651.37	3,097,851,591.34
	Найдваргүйавлага		(49,071,305.00)	(49,071,305.00)
330201	Найдваргүй авлагын хасагдуулга		(49,071,305.00)	(49,071,305.00)
	УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ТӨЛБӨР		9,820,303.10	307,223.00
330101	Цалингийн урьдчилгаа			
330501+340701	Урьдчилгаа		5,397,030.35	
340702	Бусад урьдчилгаа			
340702+34070103	Бусад урьдчилж гарсан зардал		4,423,272.75	307,223.00
	БАРАА МАТЕРИАЛ		0.00	0.00
	Түлш, шатах, тослох материал			0.00
	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		6,976,711,719.06	10,007,025,288.52
	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН			
	ҮНДСЭН ХӨРӨНГӨ		5,320,961,154.05	5,472,738,112.01
	Биет хөрөнгө		4,669,871,460.70	4,805,934,864.30
39020101	Барилга байгууламж		2,425,261,739.00	2,425,261,739.00
39020102	Хуримтлагдсан элэгдэл		(387,128,674.46)	(429,707,727.74)
39020201	Авто-тээврийн хэрэгсэл		358,602,683.42	559,158,853.71
39020202	Хуримтлагдсан элэгдэл		(261,690,350.24)	(496,112,253.88)
39020301	Машин тоног тохооромж		4,710,189,325.65	5,361,164,719.61
39020302	Хуримтлагдсан элэгдэл		(2,312,060,426.81)	(2,727,002,112.26)
39020401	Тавилга, аж ахуйн эд хогшил		256,275,136.54	258,814,236.54
39020402	Хуримтлагдсан элэгдэл		(119,577,972.40)	(145,632,590.68)
39020803	Номын фонд		0.00	0.00
	Биет бус хөрөнгө		651,089,693.35	666,803,247.71
39030101	Программ хангамж		834,113,651.45	1,031,508,462.45

Харилцаа Холбооны Зохицуулах хорооны 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан

39030102	Хасагдуулга		(183,023,958.10)	(364,705,214.74)
	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		5,320,961,154.05	5,472,738,112.01
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		12,297,672,873.11	15,479,763,400.53
	Богино хугацаат өр төлбөр			
	Өглөг		137,296,760.65	578,496,828.89
	Ажиллагчидтай холбогдсон өглөг		257,964.00	28,155,762.97
41030102	Нийгмийн даатгалын тооцоо		0.00	28,155,762.97
41030103	Татвартай хийх тооцоо		257,964.00	0.00
41030101	Цалингийн тооцоо		0.00	0.00
	Бусад өглөг		137,038,796.65	550,341,065.92
410302+410304	Байгууллагад төлөх өглөг		115,051,761.07	544,016,617.92
41030602	Хүмүүст төлөх өглөг		15,287,035.58	682,848.00
410302	БНҮҮСан			
41030601	Барьцаа		6,700,000.00	5,641,600.00
41030601	Тэмдэгтийн хураамж			
	Урьдчилж орсон орлого		0.00	2,064,344,316.91
410405+41030601	Бусад урьдчилж орсон орлого		0.00	2,064,344,316.91
41040105	Хөрөнгийн урьдчилж орсон орлого		0.00	0.00
	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН		137,296,760.65	2,642,841,145.80
	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН		137,296,760.65	2,642,841,145.80
5101	Засгийн газрын оруулсан капитал		1,169,840,273.85	1,169,840,273.85
510301	Өмнөх үеийн үр дүн		7,144,733,215.12	10,884,900,440.34
510302	Тайлант үеийн үр дүн		3,731,170,855.10	667,549,772.15
5104	Дахин үнэлгээний зөрүү		114,631,768.39	114,631,768.39
	ЦЭВЭР ХӨРӨНГӨ / ӨМЧИЙН ДҮН		12,160,376,112.46	12,836,922,254.73
	ӨР ТӨЛБӨР ЦЭВЭР ХӨРӨНГӨ / ӨМЧИЙН ДҮН		12,297,672,873.11	15,479,763,400.53

Харилцаа Холбооны Зохицуулах хорооны 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан

АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

(2016 оны 12 дугаар сарын 31-нээрх)

(төгрөгөөр)

Дансныкод	ҮЗҮҮЛЭЛТ	Тодруулга	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО			
	Үндсэн үйл ажиллагааны орлого		6,797,701,680.48	4,392,008,405.47
14020101	Үйлчилгээний орлого		6,797,701,680.48	4,392,008,405.47
	Үндсэн бус үйл ажиллагааны орлого		913,719,181.25	1,126,023,042.64
14020102+1404+1405	Бусад орлого		913,719,181.25	1,126,023,042.64
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН		7,771,420,861.73	5,518,031,448.11
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ			
	Ажиллагчидтай холбогдсон зардал		1,997,196,233.49	2,160,121,331.66
210101	Цалин		1,799,821,847.69	1,948,547,177.96
2102	НДШ, ЭМДШ		197,374,385.80	211,574,153.70
	Бараа үйлчилгээний зардал		2,226,206,352.38	2,788,296,365.11
	Тогтмол зардал		37,506,755.00	46,078,450.00
22010101	Гэрэл цахилгааны зардал		37,506,755.00	46,078,450.00
	Бусад бараа үйлчилгээний зардал		2,188,699,597.38	2,742,217,915.11
22010301	Бичиг хэргийн зардал		25,423,121.00	28,067,270.55
22010201	Түрээсийн зардал		3,282,000.00	4,855,000.00
22010302	Тээвэр, шатахууны зардал		28,291,958.00	29,123,006.85
22010303	Шуудан холбооны зардал		61,356,726.36	60,582,165.68
22020101	Хөтөлбөр арга хэмжээний зардал		631,604,741.99	952,394,430.04
22010306	Ном хэвлэлийн зардал		26,277,275.93	43,833,421.79
22010323	Хангамжийн зүйл худалдан авах зардал		14,807,585.00	24,978,235.00
22010317	Урсгал засварын зардал		43,646,122.66	65,062,340.00
22010312	Төлбөр. хураамжийн зардал		46,273,017.49	46,963,786.75
22010313	Харуул. хамгаалалтын зардал		2,160,000.00	2,160,000.00
22010314	Банкны үйлчилгээний хураамж, аудит		2,152,609.84	1,672,304.18
	Аудит		8,000,000.00	12,000,000.00
22010320	Бусад зардал		41,142,260.33	40,277,823.00
22010304	Дотоодтомилолтын зардал		27,227,860.00	38,419,057.25
22010305	Гадаад томилолтын зардал		237,194,750.32	189,113,980.00
22010308	Гадаад дотоод сургалтын зардал		7,032,570.00	5,537,999.20
22020154				
22010309	Стандарт, судалгаа шинжилгээний зардал		39,089,762.00	140,801,381.80

Харилцаа Холбооны Зохицуулах хорооны 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан

22020135	Зар сурталчилгааны зардал		50,457,350.00	52,603,542.00
22010319	Гадаад арга хэмжээ, зочны зардал		12,907,395.22	0.00
22010315	Хорооны үйл ажиллагааны зардал		105,177,266.52	79,549,053.73
22010322	Элэгдлийн зардал		775,194,951.72	899,688,517.29
2301	Их засвар			24,534,600.00
	Татаас санхүүжилт		543,046,743.20	397,778,001.81
22010316	Олон улсын байгууллагын гишүүний татвар		17,705,280.20	9,184,248.81
27030101	Нэг удаагийн тэтгэмж. Урамшуулал		380,181,424.00	386,294,163.00
22010325	Засгийн газрын мөрийн хөтөлбөр		145,160.039.00	0.00
	Бусад			2,299,590.00
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН		4,766,449,329.07	5,346,195,698.58
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН		2,944,971,532.66	171,835,749.53
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО			
	Бусад орлого		126,483,974.88	498,284,708.11
	Ханшийн зорvv /бодит/		57,065,963.98	498,284,708.11
	Бусад орлого		69,418,010.90	
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		126,483,974.88	498,284,708.11
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ			
	Хоронго худалдсаны гарз		0.00	0.00
	Үндсэн хоронго худалдсаны гарз			0.00
	Бараа материал худалдсаны гарз			0.00
	Бусад зардал		12,450,916.46	2,570,685.49
	Шууд алдагдал		0.00	0.00
	Ханшийн зорvv /бодит/		12,450,916.46	2,570,685.49
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		12,450,916.46	2,570,685.49
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН		83,878,870.64	495,714,022.62
	ҮР ДҮН		390,366,643.54	667,549,772.15

Харилцаа Холбооны Зохицуулах хорооны 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан

АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

(2016 оны 12 дугаар сарын 31-нээрх)

(төгрөгөөр)

Дансныкод	ҮЗҮҮЛЭЛТ	Тодруулга	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1402	Үндсэн вйл ажиллагааны орлого		5,089,954,651.44	7,673,916,443.41
14020101	Үйлчилгээний орлого		5,089,954,651.44	7,673,916,443.41
	Үндсэн бус вйл ажиллагааны орлого		443,260,195.17	1,431,612,095.69
ДТ(14020101)	Бусад орлого		443,260,195.17	1,431,612,095.69
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН		5,533,214,846.61	9,105,528,539.10
21	Ажиллагчидтай холбогдсон зардал		2,049,636,017.35	2,098,401,219.97
2101	Цалин холс болон нэмэгдэл урамшил		1,850,710,644.77	1,915,220,557.97
210101	Цалин		1,850,710,644.77	1,915,220,557.97
2102	Нийгмийн хамгааллын шимтгэл		198,925,372.58	183,180,662.00
21020101	НДШ, ЭМДШ		198,925,372.58	183,180,662.00
2201	Бараа үйлчилгээний урсгал зардал		1,925,159,718.18	1,852,322,340.73
220101	Тогтмол зардал		37,506,755.00	46,078,450.00
22010101	Гэрэл цахилгааны зардал		37,506,755.00	46,078,450.00
220103	Бусад бараа үйлчилгээний зардал		1,887,652,963.18	1,806,243,890.73
22010301	Бичиг хэргийн зардал		24,529,896.00	28,076,670.55
22010201	Түрээсийн зардал		3,282,000.00	4,855,000.00
22010302	Тээвэр, шатахууны зардал		28,531,740.00	26,893,237.00
22010303	Шуудан холбооны зардал		58,836,399.76	63,503,556.82
22020101	Хөтөлбөр арга хэмжээний зардал		552,664,819.28	620,574,918.10
22010306	Ном хэвлэлийн зардал		26,252,275.93	36,793,421.79
22010323	Хангамжийн зүйл худалдан авах зардал		15,531,757.00	24,943,896.00
22010317	Урсгал засварын зардал		42,408,182.66	65,062,104.00
22010320	Эд хогшил худалдан авах зардал			0.00
22010312	Толбор. хураамжийн зардал		45,864,350.00	42,540,514.00
22010313	Харуул. хамгаалалтын зардал		2,160,000.00	2,160,000.00
22010314	Банкны вйлчилгээний хураамжийн зардал		2,111,909.84	1,663,004.18
22010314	Аудитын зардал		4,000,000.00	12,000,000.00
22010320	Бусад зардал		42,761,728.00	50,763,641.79
22010304	Дотоод томилолтын зардал		27,227,860.00	40,881,200.00
22010305	Гадаад томилолтын зардал		237,828,469.00	189,248,623.56
22010308+220215404	Гадаад дотоод сургалтын зардал		7,313,208.00	5,562,899.20
22010309	Стандарт, судалгаа шинжилгээний зардал		49,164,834.00	62,656,349.00
22020135	Зар сурталчилгааны зардал		50,937,350.00	50,347,000.00
22010319	Гадаад арга хэмжээ, зочны зардал		12,831,504.22	0.00

Харилцаа Холбооны Зохицуулах хорооны 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан

2201031501	Хорооны үйл ажиллагааны зардал		108,462,384.89	83,017,439.93
22010316	Олон улсын байгууллагын гишүүний татвар		17,705,280.20	9,184,248.81
27030101	Нэг удаагийн тэтгэмж. Урамшуулал		380,195,896.00	385,516,166.00
22010325	Засгийн газрын хөтөлбөр		147,051,118.40	0.00
2.201E+09	Бүх нийтийн үүргийн сан		0.00	
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН		3,974,795,735.53	3,950,723,560.70
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		1,558,419,111.08	5,154,804,978.40
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ			
23010107	Биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардал		1,537,863,272.09	1,066,863,611.25
23010107	Их засварын зардал		0.00	0.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН		1,537,863,272.09	1,066,863,611.25
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		(1,537,863,272.09)	(1,066,863,611.25)
	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		20,555,838.99	4,087,941,367.15
ЭХ.ДТ (31)	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		2,606,749,739.09	2,627,305,578.08
ЭЦ.ДТ (31)	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		2,627,305,578.08	6,715,246,945.23

Харилцаа Холбооны Зохицуулах хорооны 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан

АУДИТЛАГДСАН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

(2016 оны 12 дугаар сарын 31-нээрх)

(төгрөгөөр)

№	ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1					
2	2014оны 12-р сарын 31 -ээрх үлдэгдэл	1,169,840,273.85	114,631,768.39	7,144,733,215.12	8,429,205,257.36
3	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
4	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				0.00
5	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0.00
6	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0.00
7	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз			672,186,264.02	672,186,264.02
8	Тайлант үеийн үр дүн			3,059,004,591.08	3,059,004,591.08
9					
10	2015оны 12-р сарын 31 -ээрх үлдэгдэл	1,169,840,273.85	114,631,768.39	10,875,924,070.22	12,160,396,112.46
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,169,840,273.85	114,631,768.39	10,875,924,070.22	12,160,396,112.46
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0.00
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0.00
15	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз			8,976,370.12	8,976,370.12
16	Тайлант үеийн үр дүн			667,549,772.15	667,549,772.15
17	2016оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,169,840,273.85	114,631,768.39	11,552,450,212.49	12,836,922,254.73

Харилцаа Холбооны Зохицуулах хорооны 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан

АУДИТЛАГДСАН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН (2016 оны 12 дугаар сарын 31-нээрх)

(төгрөгөөр)

	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	ЗӨРҮҮ	ХУВЬ
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,619,731,348.70	5,017,587,171.95	2,602,144,176.75	
II. НИЙТ ЗАРДАГЫН ДҮН	7,619,731,348.70	5,017,587,171.95	2,602,144,176.75	
IV. УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	5,327,731,348.70	3,950,723,560.70	1,377,007,788.00	
Цалин, нэмэгдэл урамшил, унаа хоолны нөхвөр	2,290,676,838.50	1,915,220,557.97	375,456,280.53	83.6
Нийгмийн даатгалын шимтгэл	251,974,452.20	183,180,662.00	68,793,790.20	72.7
Хорооны хурал, үйл ажиллагааны зардал	183,024,000.00	83,017,439.93	100,006,560.07	45.4
Бичиг хэргийн материал	40,382,000.00	28,076,670.55	12,305,329.45	69.5
Ашиглалтын зардал	46,899,816.00	46,078,450.00	821,366.00	98.2
Бензин, шатахууны зардал	49,202,992.00	26,893,237.00	22,309,755.00	54.7
Шуудан холбоо	74,160,000.00	63,503,556.82	10,656,443.18	85.6
Гадаад албан томилолт	211,554,000.00	189,248,623.56	22,305,376.44	89.5
Дотоод албан томилолт	108,543,000.00	40,881,200.00	67,661,800.00	37.7
Гадаад зочны зардал	15,000,000.00	0.00	15,000,000.00	0.0
Гадаад, дотоод сургалт	17,672,000.00	5,562,899.20	12,109,100.80	31.5
Ном хэвлэл, товхимол захиалах, хэвлэх, худалдан авах	54,400,000.00	36,793,421.79	17,606,578.21	67.6
Стандарт, баталгаажуулалт, судалгаа шинжилгээний зардал	149,474,550.00	62,656,349.00	86,818,201.00	41.9
Эд хогшил худалдан авах зардал				
Зар сурталчилгаа	94,530,000.00	50,347,000.00	44,183,000.00	53.3
Түрээсийн зардал	5,319,000.00	4,855,000.00	464,000.00	91.3
Харуул хамгаалалтын зардал	3,000,000.00	2,160,000.00	840,000.00	72.0
Урсгал засвар	66,359,000.00	65,062,104.00	1,296,896.00	98.0
Банкны үйлчилгээний хураамж	2,000,000.00	1,663,004.18	336,995.82	83.2
Аудит	12,000,000.00	12,000,000.00	0.00	100.0
Нэг удаагийн шагнал, тэтгэмж, тусламж, хөнгөлөлт	411,700,000.00	385,516,166.00	26,183,834.00	93.6
Хөтөлбөр, арга хэмжээний зардал	1,064,193,800.00	620,574,918.10	443,618,881.90	58.3
Хангамжийн зүйлс	26,937,200.00	24,943,896.00	1,993,304.00	92.6
Төлбөр, хураамж	52,406,200.00	42,540,514.00	9,865,686.00	81.2
Бусад зардал	76,322,500.00	50,763,641.79	25,558,858.21	66.5
ОУ-ын байгууллагын гишүүнчлэлийн татвар	20,000,000.00	9,184,248.81	10,815,751.19	45.9
Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардал				
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,292,000,000.00	1,066,863,611.25	1,225,136,388.75	
I. Дотоод хөрөнгө оруулалт	2,292,000,000.00	1,066,863,611.25	1,225,136,388.75	
Тоног төхөөрөмж, бусад	1,192,000,000.00	1,066,863,611.25	125,136,388.75	89.5
Дугаартайгаа шилжих үйлчилгээний төв байгуулахад шаардагдах 2016 оны ХО-лт	1,100,000,000.00	0.00	1,100,000,000.00	0.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,000,000,000.00	9,105,528,539.10	4,105,528,539.10	
Үндсэн үйлчилгээний хөлс	4,500,000,000.00	7,676,939,420.91	3,176,939,420.91	170.6
Бусад орлого	500,000,000.00	1,428,589,118.19	928,589,118.19	285.7
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	2,627,256,284.49	2,627,305,578.08	2,375,237,659.43	
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	7,524,935.79	6,715,246,945.23	6,707,722,009.44	

Харилцаа Холбооны Зохицуулах хорооны 2016 оны жилийн
эцсийн санхүүгийн тайлан
